



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ СУМЫН НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ИЛЧ ХУЖИРТ” ХХК-ИЙН  
“ХУЖИРТЫН ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРД”-ЫН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020927**

**Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 5457912**

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

<b>НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>1</b>
1.1. Төслийн нэр	1
1.2. Төслийн зорилго	1
1.3. Төсөл хэрэгжих орчны байршил	1
1.4. Ордын нөөц	3
1.5. Уурхайн ажиллах горим	4
1.6. Уурхайн бүтээгдэхүүн гаргалт	5
1.7. Хөрсний овоолго болон нүүрсний агуулах	5
1.8. Ил уурхайн процесс	6
1.9. Шимт хөрс хуулалт	6
1.10. Тэсэлгээ	7
1.11. Ухаж ачих процесс	8
1.12. Тээвэрлэх процесс	8
1.13. Овоолго үүсгэх процесс	9
1.14. Тээвэр	9
1.15. Усан хангамж	9
1.16. Цахилгаан хангамж	10
1.17. Уурхайн барилга, байгууламж	10
<b>ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b>	<b>11</b>
2.1. Төслийн гол сөрөг нөлөөлөл	11
2.2. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ	11
2.3. Газрын гадарга болон хэвлийд нөлөөлөх байдлын үнэлгээ	13
2.4. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	14
2.5. Усан орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	15
2.6. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ	18
2.7. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ	19
2.8. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ	21
2.9. Түүх соёлын өвд үзүүлэх нөлөөлөл	22
<b>ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>23</b>
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	23
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	28
3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	28
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	29
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	29
3.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	29
3.7. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	29
3.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
3.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30
3.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	30
3.11. Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хэлэлцүүлэх хуваарь	33
3.12. “Тэрбум мод” төслийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө	33
3.13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	34

### Зургийн жагсаалт

Зураг 1.	Хужиртын нүүрсний уурхайн байршил.....	2
Зураг 2.	Уурхайн ашиглалтын 2024 оны төгсгөл дэх дэвсгэр зураг .....	5

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.	Төсөл хэрэгжих талбайн солбилцол .....	1
Хүснэгт 2.	“Илч хужирт” ХХК-ийн хэрэгжүүлэх төслийн ерөнхий мэдээлэл .....	3
Хүснэгт 3.	Хужиртын нүүрсний уурхайн нөөцийн мэдээлэл .....	4
Хүснэгт 4.	Уурхайн ажиллах горим .....	4
Хүснэгт 5.	Уурхайн бүтээгдэхүүн гаргалтын календарьчилсан төлөвлөлт – 2024 он .....	5
Хүснэгт 6.	Хөрсний овоолгын дизайны нөхцөл .....	5
Хүснэгт 7.	Хөрсний чулуулгийн хэмжээ болон шилжүүлэх байршил .....	6
Хүснэгт 8.	Хуулах шимт хөрсний хэмжээ .....	6
Хүснэгт 9.	Уурхайн талбай дахь объектуудын хэмжээ .....	6
Хүснэгт 10.	Тэсэлгээний ажлын тооцоо /нүүрс олборлолт/ .....	7
Хүснэгт 11.	Тэсэлгээний ажлын тооцоо – хөрс .....	8
Хүснэгт 12.	Ундны усны хэрэглээ .....	9
Хүснэгт 13.	Зам талбайн усалгаанд зарцуулах усны хэрэглээ .....	10
Хүснэгт 14.	Ил уурхайд шаардлагатай барилга байгууламжууд .....	10
Хүснэгт 15.	Нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүн .....	11
Хүснэгт 16.	Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц .....	11
Хүснэгт 17.	Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт .....	12
Хүснэгт 18.	Газрын гадарга болон хэвлийд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц .....	13
Хүснэгт 19.	Газрын гадарга болон газрын хэвлийд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт .....	13
Хүснэгт 20.	Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц .....	14
Хүснэгт 21.	Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт .....	15
Хүснэгт 22.	Хужиртын ордын геологийн үзүүлэлт .....	15
Хүснэгт 23.	Ус шүүрэлтийн тооцоо .....	16
Хүснэгт 24.	Ус шүүрэлтийн тооцоо ашиглалтын жилээр .....	16
Хүснэгт 25.	Ус орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц .....	17
Хүснэгт 26.	Газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний дүгнэлт .....	18
Хүснэгт 27.	Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц .....	18
Хүснэгт 28.	Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт .....	19
Хүснэгт 29.	Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц .....	20
Хүснэгт 30.	Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт .....	20
Хүснэгт 31.	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгдсэн дүн ..	20
Хүснэгт 32.	Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл .....	21
Хүснэгт 33.	Уурхайн нөлөөллийн бүсэд хамрагдах өрхүүд .....	21
Хүснэгт 34.	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт .....	22
Хүснэгт 35.	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө .....	24
Хүснэгт 36.	Нөхөн сэргээлтээр хийх ажлын хэмжээ .....	28
Хүснэгт 37.	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	30
Хүснэгт 38.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	31
Хүснэгт 39.	Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....	33
Хүснэгт 40.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл .....	34

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн нэр

“Чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах”

### 1.2. Төслийн зорилго

Төсөл хэрэгжүүлэгч “Илч хужирт” ХХК нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт орших Хужиртын чулуун нүүрсний ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд мөрдөх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Илч хужирт” ХХК, Регистрийн дугаар: 5457912, Улсын бүртгэлийн дугаар: 9011260041 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-хороо, Энх тайвны өргөн чөлөө, 15А-5 тоот. Утас: 99113065


### 1.3. Төсөл хэрэгжих орчны байршил

Хужиртын нүүрсний орд нь засаг захиргааны хувьд Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт байрладаг. Улаанбаатар хотоос баруун хойш 500 км, Түшиг сумаас зүүн хойш 15 км, аймгийн төв Сүхбаатар хотоос баруун хойш 135 км тус тус зайтай оршино. Талбайн номенклатурын хувьд М-48-55 планшетэд байрлана. Улаан-Овоогийн нүүрсний уурхайгаас зүүн тийш 25 км, Зэлтэрийн боомтоос 8 км, төмөр замын Шаамар өртөөнөөс зүүн урагш 100 км тус тус зайтай.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол

№	Талбайн байршил /1794.81 га/		№		
1	105°12'16.43"	50°22'2.38"	24	105° 16' 24.88"	50°22'41.75"
2	105° 12' 16.43"	50°21'59.98"	25	105° 16' 23.02"	50°22'41.24"
3	105° 11' 51.31"	50°21'59.98"	26	105° 16' 21.43"	50о 22' 40.61"
4	105° 11' 51.31"	50°22'1.69"	27	105° 16' 20.07"	50о 22' 39.86"
5	105° 11' 17.58"	50°22'1.69"	28	105° 16' 18.84"	50о 22' 38.94"
6	105° 11' 17.58"	50°21'59.92"	29	105° 16' 16.25"	50° 22' 38.91"
7	105° 10' 42.41"	50°21'59.92"	30	105° 16' 14.29"	50° 22' 38.74"
8	105° 10' 42.41"	50°21'57.53"	31	105° 16' 12.19"	50°22' 38.39"
9	105° 10' 14.01"	50°21'57.53"	32	105° 16' 10.29"	50° 22' 37.92"
10	105° 10' 14.01"	50°21'47.9"	33	105° 16' 8.95"	50° 22' 37.49"
11	105° 9' 40.28"	50°21'47.9"	34	105° 16' 7.62"	50° 22' 37"
12	105 9' 40.28"	50°21'39.5"	35	105° 16' 3.46"	50° 22' 35.17"
13	105° 9' 22.8"	50°21'39.5"	36	105° 15' 57.18"	50° 22' 32.75"
14	105° 9' 22.8"	50°23'16.99"	37	105° 15' 54.69"	50° 22' 31.86"
15	105° 17' 1.1"	50°23'16.99"	38	105° 15' 52.58"	50° 22' 31.23"
16	105° 17' 1.1"	50°22'44.98"	39	105° 15' 49.12"	50° 22' 30.54"
17	105° 16' 36.56"	50°22'44.98"	40	105°15' 47.19"	50° 22' 30.07"
18	105° 16' 36.56"	50°22'43.27"	41	105° 15' 44.95"	50° 22' 29.34"
19	105° 16' 35.58"	50°22'42.79"	42	105° 15' 42.75"	50° 22' 28.46"
20	105° 16' 33.56"	50°22'42.69"	43	105° 15' 38.98"	50° 22' 28.38"
21	105° 16' 30.48"	50°22'42.34"	44	105°15' 36.12"	50о 22' 28.12"
22	105° 16' 27.67"	50°22'42.17"	45	105° 15' 33.57"	50о 22' 27.65"
23	105° 16' 26.31"	50°22'42.01"			

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1. Хужиртын нүүрсний уурхайн байршил

Тус компани нь анх 2011 оны 05-р сарын 16-нд Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт орших “Хужирт” нэртэй 4759.17 га талбай бүхий XV-012221 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг “Очир” ХХК-аас шилжүүлэн авсан бөгөөд 2007-2016 онуудад хайгуулын ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж А+В+С зэргээр нийт 360,984.63 мян. тн нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

Улмаар 2017 оны 09-р сард АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр “Хужирт” 1794.81 га талбай бүхий MV-020927 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан.

Хүснэгт 2. “Илч хужирт” ХХК-ийн хэрэгжүүлэх төслийн ерөнхий мэдээлэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
<b>1 Ерөнхий мэдээлэл</b>		
1.1 Төсөл хэрэгжүүлэгч компани		"Илч Хужирт" ХХК
1.2 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар		9011260041
1.3 Тусгай зөвшөөрлийн дугаар		MV-020927
1.4 Ашигт малтмалын төрөл		Чулуун нүүрс
1.5 Ордын байршил		Сэлэнгэ аймаг Түшиг сум
1.6 Орд ашиглалтын хугацаа		15 жил
<b>2 Геологийн хэсэг</b>		
2.1 Нөөцийн тайлангийн дүгнэлтийн дугаар, огноо		2017 оны 02-р сарын 02 (ХХ-01-05)
2.2 Нөөц бүртгэх тухай тушаалын дугаар, огноо		2017 оны 03-р сарын 15 (н-06)
2.3 Нийт нүүрсний нөөц (А+В+С)	мян.тн	360,984.63
2.4 Оновчлолоор тодорхойлсон ил уурхайн хүрээн дэх нөөц	сая.тн	115.6
2.5 Нүүрсний хаягдлын хэмжээ	%	3
2.6 Нүүрсний бохирдлын хэмжээ	%	12
2.7 Үйлдвэрлэлийн нөөц	сая.тн	12.4
2.8 Нүүрсний эзлэхүүн жин	тн/м <sup>3</sup>	1.26
2.9 Чулуулгийн эзлэхүүн жин	тн/м <sup>3</sup>	2.5
<b>3 Технологийн хэсэг</b>		
3.1 Ажилчдын тоо	Хүн	154-190
3.2 Уурхайн жилийн хүчин чадал	сая.тн	1.0
3.3 Уурхайн ашиглалтын жил	жил	15
3.4 Уурхайн нийт хөрс хуулалт	сая.м <sup>3</sup>	36.2
3.5 Хөрс хуулалтын дундаж коэффициент	м <sup>3</sup> /тн	3.78
3.6 Ашиглалтын систем: Автотээвэртэй, гадаад болон дотоод овоолготой ашиглалтын систем		
3.7 Хэрэглэх тэсрэх бодис	Анфо болон Эмульс	
3.8 Жилийн ажиллах хоногийн тоо	Хоног	353
3.9 Ээлжийн тоо	Ээлж	2
3.10 Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	12
3.11 Жилд ажиллах цэвэр ажлын цаг	Цаг	6,601
<b>4 Дэд бүтэц</b>		
4.1 Цахилгааны эх үүсвэр	Төвийн шугамд холбогдоно	
4.2 Нийт цахилгаан хэрэглээ	мян.кВт.цаг/жил	4,417.7
4.3 Усны эх үүсвэр	Гүний худаг	
4.4 Нийт усны хэрэглээ	мян.м <sup>3</sup>	907
<b>5 Эдийн засаг</b>		
5.1 Төслийн нийт хөрөнгө оруулалт	тэрбум.төг	57.0
5.2 Цалингийн зардал жилд дунджаар	сая.төг/жил	3,837.1
5.3 Хөдөлмөр хамгааллын зардал дунджаар	сая.төг/жил	259.1

#### 1.4. Ордын нөөц

Хужиртын нүүрсний ордын нөөцийн тооцоонд жишгийн доорх шаардлагыг авч хэрэглэсэн.

- ✚ Нүүрсний давхраасын нөөц тооцох хамгийн бага зузаан – 0.7 м
- ✚ Нүүрсний бохирдолт тооцох чулууны үеийн хамгийн их зузаан – 0.3 м
- ✚ Бохирдол тооцсон үнслэгийн дээд хязгаар – 35%
- ✚ Уурхайн хажуугийн тогтворжилтын өнцөг – 35°

Ордын бүлгийн хувьд Хужиртын ордыг бүхэлд нь геологийн тогтцын нийлмэл байдал, нүүрсний давхраасын морфологи, зузааны өөрчлөлт, нүүрсний чанар зэргээс хамааруулан I бүлгийн ордод хамааруулсан байна.

Хүснэгт 3. Хужиртын нүүрсний уурхайн нөөцийн мэдээлэл

Нөөцийн зэрэг		Нүүрсний давхраасын дугаар					Нийт, мян.тн
		2-1 багц	2-2 багц	3	4	5	
Баттай нөөц (А)	Цэвэр нүүрс	4,127.50	10,921.44	2,755.01	-	-	17,803.95
	Чулууны үетэй нүүрс	4,219.77	11,434.95	2,814.53	-	-	18,469.25
Бодитой нөөц (В)	Цэвэр нүүрс	27,082.38	68,854.96	33,484.47	14,568.65	1,251.50	145,241.96
	Чулууны үетэй нүүрс	27,954.73	71,101.71	34,481.48	14,842.90	1,256.40	149,637.23
Боломжтой нөөц (С)	Цэвэр нүүрс	44,382.31	99,829.55	33,963.30	12,067.53	7,696.03	197,938.72
	Чулууны үетэй нүүрс	46,578.13	102,915.44	34,920.25	12,152.17	7,742.79	204,308.77
Баялаг (P1)	Цэвэр нүүрс	13,512.59	19,082.07	-	-	-	32,594.67
	Чулууны үетэй нүүрс	14,097.93	19,657.83	-	-	-	33,755.77
Нийт нөөц, мян.тн	Цэвэр нүүрс	89,104.79	198,688.02	70,202.78	26,636.19	8,947.53	393,579.30
	Чулууны үетэй нүүрс	92,850.56	205,109.93	72,216.26	26,995.07	8,999.19	406,171.01

### 1.5. Уурхайн ажиллах горим


Уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй 353 хоног ажиллана. Үлдсэн 12 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар тооцов. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар ажиллана. Хүснэгт 4-д ил уурхайн ажиллах ээлжийн зохион байгуулалтыг харуулав.

Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим

Үзүүлэлт	Нэгж	Утга
<b>Уурхайн жилд ажиллах хоног</b>		
Календарийн хоногийн тоо	хоног	365
Баяр ёслол, цаг агаарын саатал, сул зогсолт	хоног/жил	12
Жилд ажиллах хоног	хоног/жил	353
Жилд ажиллах цаг	цаг/жил	8472
<b>Ээлжийн зохион байгуулалт</b>		
Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж/хон	2
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг/ээлж	12
<b>Засвар үйлчилгээний цаг</b>		
Төлөвлөгөөт их засвар үйлчилгээ	цаг/жил	826.02
Урсгал засвар үйлчилгээ	цаг/жил	444.78
Нийт засвар үйлчилгээ	цаг/жил	1270.8
<b>Техникийн бэлэн байдал</b>	%	<b>85%</b>
<b>Ээлжийн цаг ашиглалт</b>		
Үзлэгийн хугацаа	мин/ээлж	15
Ээлж солилцох хугацаа	мин/ээлж	10
Хоолны цаг	мин/ээлж	60
Ул цэвэрлэх, тавцан засах, шилжилт хийх хугацаа	мин/ээлж	20
Бүтээлгүй ажиллах нийт хугацаа	цаг/ээлж	1.75
Ээлжинд бүтээлтэй ажиллах цаг	цаг/ээлж	10.25
<b>Ашиглалтын бэлэн байдал</b>	%	<b>85.4%</b>
<b>Хоногт цаг ашиглалт</b>	<b>цаг/хон</b>	<b>20.5</b>
Ээлжинд хөдөлгүүр унтрах хугацаа	цаг/ээлж	1.0
Ээлжинд хөдөлгүүр ажиллах хугацаа	цаг/ээлж	11.0
Хөдөлгүүр ашиглалтын коэффициент	%	91.7%
<b>Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн жилд ажиллах цаг</b>		
<b>Бүтээмж</b>	<b>%</b>	<b>90%</b>
Хөдөлгүүр ажиллах цаг	цаг/жил	6601.1
Бүтээлтэй ажиллах цаг	цаг/жил	5535.9

## 1.6. Уурхайн бүтээгдэхүүн гаргалт

Төслийн хүчин чадал нь жилийн 0.2-1.0 сая.тн нүүрс байна. Төслийн хүчин чадлыг ашиглалтыг 6 дахь жилээс 2 дахин нэмэгдүүлнэ. Уурхайн ашиглалтын хугацаа нь 119 жил байх бөгөөд эхний 15 жилээр бүтээгдэхүүн гаргалтын календарчилсан төлөвлөгөөг ТЭЗҮ-д нарийвчлан гаргасан.



Зураг 2. Уурхайн ашиглалтын 2024 оны төгсгөл дэх дэвсгэр зураг

Хүснэгт 5. Уурхайн бүтээгдэхүүн гаргалтын календарчилсан төлөвлөлт – 2024 он

Ашиглалтын жил	Геологийн нөөц			Хаягдал бохирдол	
	Нүүрс, тн	Хөрс, м <sup>3</sup>	Уулын цул, м <sup>3</sup>	Хаягдал 3%	Бохирдол 12%
2024 он	179,222	662,960	805,200	5,377	21,507
	Үйлдвэрлэлийн нөөц				
	Нүүрс, тн	Хөрс, м <sup>3</sup>	Уулын цул, м <sup>3</sup>	Хөрс хуулалтын коэффициент	
	195,352	609,848	805,200	3.12	

## 1.7. Хөрсний овоолго болон нүүрсний агуулах

Уурхайгаас гарах хаягдал хөрсний чулуулгийг эхний жилд уурхайн зүүн хойд зүгт хөрсний гадаад овоолго үүсгэн шилжүүлнэ. 5 дахь жилээс дотоод овоолго үүсгэж эхэлнэ. Овоолго болон нүүрсний агуулах дахь чулуулгийн сийрэгжилт нь дунджаар 30% байна. Овоолгын траншейн замын налуу нь 10%. Траншейн замын өргөн 25 м байна. Овоолгын дизайны үзүүлэлтүүдийг Хүснэгт 6-д, овоолгын багтаамжийг Хүснэгт 7-д тус тус үзүүлэв.

Хүснэгт 6. Хөрсний овоолгын дизайны нөхцөл

Овоолгын хажуугийн өнцөг	35°
Овоолго дахь материалын сийрэгжилт	30 %
Эзлэхүүн жин (сийрэгжсэн)	1.92 м <sup>3</sup> /тн



Хүснэгт 7. Хөрсний чулуулгийн хэмжээ болон шилжүүлэх байршил

Байршил	Талбай, га	Сийрэгжсэн эзлэхүүн, сая. м <sup>3</sup>
Хөрсний гадаад овоолго	74	35.0
Хөрсний дотоод овоолго	38	12.0

Овоолгын дизайн нь техникийн нөхөн сэргээлтийн үед 18 градусын налуутай түрж налуулах ажлыг хамгийн бага байхаар тооцож гүйцэтгэсэн.

### 1.8. Ил уурхайн процесс

Ил уурхайн процесс нь уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилтод бүтээмжийг хангах ёстой.

Ил уурхайнд дараах үндсэн процессууд явагдана. Үүнд:

- ✚ Өрөмдлөг, тэсэлгээ
- ✚ Ухаж ачих
- ✚ Тээвэрлэх
- ✚ Овоолго үүсгэх

### 1.9. Шимт хөрс хуулалт

Ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.3-0.8 м зузаантайгаар урьдчилан хуулна. Хуулж бэлтгэсэн шимт хөрс нь ордын ашиглалтын явцад болон ордыг ашиглаж дууссаны дараах нөхөн сэргээлтийн ажилд ашиглагдах юм. Шимт хөрсний овоолгын өндөр нь 2 м байх бөгөөд хажуугийн тогтворжилтын өнцөг нь 25-33 градус байна. Шимт хөрсийг хуурай сэрүүний улиралд хуулах нь тохиромжтой бөгөөд овоолгыг аль болох нөмөр газар хийх ба тийм боломжгүй тохиолдолд шимт хөрсний овоолгыг сууж дагтарштал нь тусгай зориулалтын торон хучилт хийж салхи шуурганд хийсэхээс сэргийлэх болон ургамалжуулж болно. Шимт хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна. Шимт хөрс хуулалтын ажилд CAT-D8R маркийн бульдозер ашиглана.

Хүснэгт 8. Хуулах шимт хөрсний хэмжээ

№	Эвдрэл үүсэх талбай	Хэмжээ, га	Шимт хөрсний хуулах зузаан, м	Хуулах шимт хөрсний хэмжээ, м <sup>3</sup>
1	Ил уурхай	579.70	0.3	1,739,100
2	Хөрсний овоолго	20.00	0.3	60,000
3	Зам талбай	18.50	0.3	55,500
4	Барилга байгууламж	2.50	0.3	7,500
5	Засварын газар	1.00	0.3	3,000
6	Тэсрэх бодисын агуулах	0.55	0.3	1,650
7	Бусад	5.00	0.3	15,000
	<b>Дүн</b>	<b>627.25</b>		<b>1,881,750</b>

Хүснэгт 9. Уурхайн талбай дахь объектуудын хэмжээ

Эвдрэл үүсэх талбай	Хэмжээ, га	Шимт хөрсний хуулах зузаан, м	Хуулах шимт хөрсний хэмжээ, м <sup>3</sup>
1   Ил уурхай	579.70	0.3	1,739,100
2   Хөрсний овоолго	20.00	0.3	60,000
3   Зам талбай	18.50	0.3	55,500
4   Барилга байгууламж	2.50	0.3	7,500
5   Засварын газар	1.00	0.3	3,000

6	Тэсрэх бодисын агуулах	0.55	0.3	1,650
7	Бусад	5.00	0.3	15,000
Дүн		627.25		1,881,750

### 1.10. Тэсэлгээ

Тэсэлгээний ажлыг 14 хоногт 1 удаа явуулна. Нийт тэсрэх бодисын 40% ANFO буюу энгийн тэсрэх бодис, үлдсэн 60%-д эмульсийн тэсрэх бодис ашиглана. Тэсрэх бодисын хувийн зарцуулалт хөрсөнд 0.50 кг/м<sup>3</sup>, нүүрсэнд 0.45 кг/м<sup>3</sup> тус тус байна. Тэсэлгээний хэрэгсэлд цооногийн детенатор, гадаргуун детенатор, өдөөгч, гал дамжуулах утас /ОША/ зэргийг ашиглана. Тэсэлгээний ажлын тооцоог хөрс болон нүүрсэнд тус тусад нь тооцсон.

**Тэсрэх материалын агуулах:** Тэсэлгээний агуулахыг уурхайн талбайгаас урд зүгт 1 км зайд барина. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу тэсэлгээний агуулахыг бат бэх, шатамхай бус материалаар буюу галд тэсвэртэй материалаар хийгдсэн, гал авалцахгүй материалаар доторлогдсон, чийг авах, хэт халахаас сэргийлэх зорилгоор дээд ба доод хэсэгт агааржуулагч нүхтэй, дотор нь юу агуулж байгааг заасан зохих анхааруулах тэмдэгтэй байна. Дотор талыг нь байнга цэвэр хуурай байлгана. Эргэн тойронд тал тал руугаа 10м-с дотогш зайд хог новш, хуурай өвс, модгүй орчинд агуулах барин хадгална. Тэсрэх материалыг аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Хүснэгт 10. Тэсэлгээний ажлын тооцоо /Нүүрс олборлолт/

№	Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын жил
			2024 он
1	Нүүрсний хэмжээ	м <sup>3</sup>	142,240
2	Нүүрсний эзлэхүүн жин	тн/м <sup>3</sup>	1.26
3	Цооногийн диаметр	м	0.165
<b>Тэсэлгээний блок</b>			
4	Нэг тэсэлгээнд хамаарах блокийн эзлэхүүн	м <sup>3</sup>	5,641
5	Урт	м	28
6	Өргөн	м	20
7	Тэслэх доголын өндөр	м	10
<b>Цооног</b>			
8	Тэсэлгээний нэг блок дахь цооногийн тоо	ш	22
9	Эгнээний тоо	ш	4
10	Цооногийн гүн	м	11.2
11	Илүү өрөмдлөгийн гүн	м	1.2
12	Цооногийн налуу	град	90
13	Улны эсэргүүцлийн шугам /тэслэх нөхцөл/	м	5.9
14	Улны эсэргүүцлийн шугам /өрөмдөх нөхцөл/	м	5.1
15	Цооног хоорондын зай	м	5.0
16	Эгнээ хоорондын зай	м	5.0
<b>Тэсэлгээний үзүүлэлтүүд</b>			
17	Тэсрэх бодисын төрөл	Анфо болон Эмульсын тэсрэх бодис	
18	ТБ-ын хувийн зарцуулалт	кг/м <sup>3</sup>	0.45
19	Түгжээсний урт	м	4.1
20	Цэнэгийн урт	м	7.0
21	Цэнэглэлтийн нягт	кг/м <sup>3</sup>	1100
22	1 м цооногийн багтаамж	кг/м	23.51
23	1 цооногт орох тэсрэх бодис	кг	165.27
24	Блокод шаардлагатай ТБ	кг	3566
25	<b>1м цооногоос гарах уулын цул</b>	<b>м<sup>3</sup>/м</b>	<b>23.4</b>
<b>Тэсэлгээ хийх горим</b>			
26	Тэсэлгээ хийх хоногийн мөчлөг	хоног	14
27	Жилд хийх тэсэлгээний тоо	удаа	25
<b>Тэсэлгээний аюултай бүсүүд</b>			
28	Шидэлтийн аюултай бүс (хүнд)	м	250

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

29	Шидэлтийн аюултай бүс (т.төх)	м	125
30	Цохилтын аюултай бүс (хүнд)	м	597
31	Цохилтын аюултай бүс (т.төх)	м	297
32	Чичиргээ доргионы аюултай бүс	м	113

Хүснэгт 11. Тэсэлгээний ажлын тооцоо – Хөрс

№	Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын жил
			2024 он
1	Хөрсний хэмжээ	м <sup>3</sup>	662,960
2	Хөрсний эзлэхүүн жин	тн/м <sup>3</sup>	2.50
3	Цооногийн диаметр	м	0.165
<b>Тэсэлгээний блок</b>			
4	Нэг тэсэлгээнд хамаарах блокийн эзлэхүүн	м <sup>3</sup>	26,293
5	Урт	м	131
6	Өргөн	м	20
7	Тэслэх доголын өндөр	м	10
<b>Цооног</b>			
8	Тэсэлгээний нэг блок дахь цооногийн тоо	ш	102
9	Эгнээний тоо	ш	4
10	Цооногийн гүн	м	11.2
11	Илүү өрөмдлөгийн гүн	м	1.2
12	Цооногийн налуу	град	90
13	Улны эсэргүүцлийн шугам /тэслэх нөхцөл/	м	5.6
14	Улны эсэргүүцлийн шугам /өрөмдөх нөхцөл/	м	5.1
15	Цооног хоорондын зай	м	5.0
16	Эгнээ хоорондын зай	м	5.0
<b>Тэсэлгээний үзүүлэлтүүд</b>			
17	Тэсрэх бодисын төрөл	Анфо болон Эмульсын тэсрэх бодис	
18	ТБ-ын хувийн зарцуулалт	кг/м <sup>3</sup>	0.50
19	Түгжээсний урт	м	4.1
20	Цэнэгийн урт	м	7.0
21	Цэнэглэлтийн нягт	кг/м <sup>3</sup>	1100
22	1 м цооногийн багтаамж	кг/м	23.51
23	1 цооногт орох тэсрэх бодис	кг	165.27
24	Блокод шаардлагатай ТБ	кг	16866
25	<b>1м цооногоос гарах уулын цул</b>	<b>м<sup>3</sup>/м</b>	<b>23.1</b>
<b>Тэсэлгээ хийх горим</b>			
26	Тэсэлгээ хийх хоногийн мөчлөг	хоног	14
27	Жилд хийх тэсэлгээний тоо	удаа	25
<b>Тэсэлгээний аюултай бүсүүд</b>			
28	Шидэлтийн аюултай бүс (хүнд)	м	250
29	Шидэлтийн аюултай бүс (т.төх)	м	125
30	Цохилтын аюултай бүс (хүнд)	м	1298
31	Цохилтын аюултай бүс (т.төх)	м	496
32	Чичиргээ доргионы аюултай бүс	м	113

### 1.11. Ухаж ачих процесс

Уурхайд нүүрс олборлолтод 2.4 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай CAT-349D2L болон хөрс хуулалтад 7.0 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай CAT-6015 маркийн 1ш экскаватор ажиллуулахаар тооцсон.

### 1.12. Тээвэрлэх процесс

Уурхайд хөрс хуулалт болон нүүрс олборлолтод ажиллах CAT-349D2L болон CAT-6015 маркийн экскаваторуудтай хосолж ажиллах байдлаар хөрс хуулалтад 64 тн даацтай Howo маркийн автосамосвал, нүүрс олборлолтод 30 тн-н даацтай Howo маркийн автосамосвал ажиллана.

Тээврийн зайн хувьд нүүрсийг нүүрс буулгах талбайд хураана, хөрсийг гадаад овоолгод хураана.

### 1.13. Овоолго үүсгэх процесс

Уурхайн ашиглалтын 15 жилийн хугацаанд нийт 36.1 сая.м<sup>3</sup> буюу сийрэгжсэн эзлэхүүнээр 47.0 сая.м<sup>3</sup> хөрсний гадаад болон дотоод овоолго үүснэ. Жил бүрийн овоолгын ажлын хэмжээнээс хамаарч овоолгын ажилд CAT-D8 маркийн бульдозер 1 ширхэг ажиллана.

### 1.14. Тээвэр

Нүүрсний агуулахын талбайгаас 15 жилийн хугацаанд нийтдээ 12.4 сая.тн нүүрс борлуулах ба нүүрс борлуулалтыг Сэлэнгэ аймгийн Түшиг суманд байх уурхайгаас баруун хойд зүгт 8 км зайтай Зэлтэрийн боомт хүртэл тавих хатуу хучилттай замаар дамжуулан тээвэрлэнэ.

### 1.15. Усан хангамж

#### Ундны ус

Уурхайн ажилчдын ундны усны хэрэглээг БОНХАЖ сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” А/301-р тушаалын 12-р хавсралтад заасны дагуу “Төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системд холбогдоогүй орон сууц”-д 1 хүн 150 л/хон байхаар тооцлоо. Уурхайд нийт 154-190 хүн харилцан адилгүй нэгэн зэрэг ажиллах бөгөөд эдгээр ажилчдын ундны усны хэрэгцээг 1 ширхэг 1.1 л/сек ундаргатай гүний худгаар хангана.

Хүснэгт 12. Ундны усны хэрэглээ

Үзүүлэлт	Норм, л/хоног	Усны зарцуулалт, м <sup>3</sup> /жил
		2024 он
Уух усанд	14.4	783
Хоол	14.4	783
Угаалга	12.0	652
Гар нүүр угаах	4.8	261
Шүршүүр	36.0	1,957
Ахуйн хэрэглээнд	19.2	1,044
Угаалга, үйлчилгээ	49.2	2,675
<b>Нийт</b>	<b>150.0</b>	<b>8,154</b>

#### Зам талбайн усалгааны ус

Ил уурхайд шаардлагатай технологийн ус хангамжид уурхайн дотоод замын тоос дарах, ногоон байгууламж, талбайн усалгаа болон тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай усны хэрэглээ багтана. Ногоон байгууламжийн усалгааг БОНХАЖ сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” А/301-р тушаалын 13-р хавсралт заасны дагуу “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-д 1 м<sup>2</sup> талбайд 4 л, “Технологийн хэрэглээ буюу зам, талбайн усалгаа”-д 1 м<sup>2</sup> талбайд 2 л гэсэн нормыг тус тус баримталж ус хэрэглээний тооцоог хийлээ.

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4-10 сард буюу дулааны улиралд явуулна. 11-3-р сард буюу өвлийн улирал замыг грейдерээр хусаж цэвэрлэнэ. Усны машин нь тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замыг хэсэгчлэн тоос

дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Хэрэв цаг агаар, хөдөлгөөний эрчмийн байдлаас шалтгаалан тоосжилт ихэсвэл замын тоос дарах ажиллагааг дахин давтана.

Хүснэгт 13. Зам талбайн усалгаанд зарцуулах усны хэрэглээ

Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын жил
		2024 он
Усалгааны замын урт	мян.м	1.4
Замын өргөн	м	20
Талбай	мян.м <sup>2</sup>	28.0
Хоногт услах тоо	ш	1
Усалгааны норм	л/м <sup>2</sup>	6
<b>Жилд хэрэглэх усны хэмжээ</b>	<b>мян.м<sup>3</sup>/жил</b>	<b>59.3</b>

#### 1.16. Цахилгаан хангамж

Уурхай нь жилд 1 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтай бөгөөд уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд бүгд дизель хөдөлгүүртэй. Төвийн бүсийн төвлөрсөн системд холбогдож үйл ажиллагаа явуулна. Уурхайд шаардлагатай нийт цахилгаан хэрэглээнд тулгуурлан, цахилгаан хангамжийн систем, дагалдах байгууламжууд иж бүрнээр баригдана.

#### 1.17. Уурхайн барилга, байгууламж

Хужиртын уурхайд ажилчдын амьдрах байр, оффисын байр, цайны газар, засварын цех, хамгаалалтын албаны байр, агуулах /ил агуулах, сэлбэг материалын агуулах, материалын агуулах, тэсрэх бодисын агуулах/-ын байгууламж, шатахуун түгээх станц, нүүрс ачилтын талбай болон хяналтын байр зэрэг уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай байгууламжуудыг барьж байгуулан ашиглана.

Хүснэгт 14. Ил уурхайд шаардлагатай барилга байгууламжууд

№	Барилга байгууламж	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Ажилчдын байр	ш	1
2	Оффисын байр	ш	1
3	Цайны газар	ш	1
4	Амралт чөлөөт цаг өнгөрүүлэх байр	ш	1
5	Хяналтын байр	ш	1
6	Засварын цех	ш	1
7	Нүүрс ачилтын талбайн хяналтын байр	ком	1
8	Шатахуун түгээх станц	ком	1
9	Тэсрэх материалын агуулах	ком	1

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1. Төслийн гол сөрөг нөлөөлөл

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт хэрэгжүүлэх “Чулуу нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслөөс байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын ус, газрын доорх ус, хөрс, ургамал, амьтанд үзүүлэх байдлаар нь үнэлж, үр дүнг тодорхойлоход дараах үнэлгээтэй байна.

Хүснэгт 15. Нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүн

Нөлөөлөлд өртөгч		Байгаль орчны сөрөг нөлөөллийн түвшин		
		Их	Дунд	Бага ба нөлөөгүй
Газрын гадарга	Барилга байгууламж, агуулах сав, тоног төхөөрөмж		Дунд богино хугацаатай	
Агаарын чанарт үзүүлэх нөлөө		Их		
Газрын хэвлийд үзүүлэх нөлөө		Их		
Гадаргын усанд үзүүлэх нөлөө			Дунд	
Газрын доорх усанд үзүүлэх нөлөө		Их		
Хөрсөнд үзүүлэх нөлөө		Их		
Ургамалд үзүүлэх нөлөө		Их		
Амьтны аймагт үзүүлэх нөлөө			Дунд	

Нэгдсэн дүнгээс үзвэл төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихтэй гэсэн үзүүлэлт гарлаа. Учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээ, зөвлөмж болон хяналт үнэлгээг байгаль орчны хүчин зүйл тус бүрээр боловсруулан тайланд тусгасан.

Төслийн сөрөг нөлөөллүүд нь төслийн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа болно. Хүснэгт голлох сөрөг нөлөөллийг төслийн үйл ажиллагаа болон байршилтай холбогдуулан схемчлэн харуулав.

### 2.2. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

Төслийн зүгээс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь хөрс хуулах, овоолго үүсгэх, машин механизмын хөдөлгөөнөөс тоос босох, хорт хий ялгарах зэрэг орно. Тухайлбал:

- ✚ Хөрс хуулах, нүүрс олборлох үед тоос, шороо ихээр үүсэх
- ✚ Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо
- ✚ Уурхайд ажиллах машин техникүүдийн шингэн түлшний шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд

Хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ, утаа тортог, тоос шороо дэгдэх зэргээр агаарын орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Хүснэгт 16. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Үйл ажиллагаа	Боломжит/Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн үнэлгээ
---	---------------------------------	---------------	-----------------------------	-----------------------	--------------------

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Агаарын чанар	Газар шорооны ажил	Хөрс хуулалтын явцад ухаж ачих, тээвэрлэх, овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсч агаарын чанарт нөлөөлөх	3-Ноцтой	Их
2	Агаарын чанар	нүүрс олборлолт	Нүүрс олборлон ухаж ачих, тээвэрлэх, овоолгод хураах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсэн агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	3-Ноцтой	Их
3	Агаарын чанар	Гадаад болон дотоод овоолго үүсгэх	Хөрс, элсний овоолго байгуулах, тээвэрлэх явцад тоосжилт үүсч агаарын чанарт нөлөөлөх	3-Ноцтой	Их
4	Агаарын чанар	Тээвэрлэлт	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч элэгдэн, сул шороо үүссэнээр тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	2-Дунд зэрэг	Дунд
5	Агаарын чанар	Засвар үйлчилгээ	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршимтгай органик нэгдлүүд агаарт дэгдэж тухайн орчны агаар болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	3-Ноцтой	Их
6	Агаарын чанар		Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	2-Дунд зэрэг	Дунд
7	Агаарын чанар	Шатахуун хадгалах, түгээх	Шатахуун тээвэрлэлтээс тоосжилт үүсэх	2-Дунд зэрэг	Дунд
8	Агаарын чанар		Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог	2-Дунд зэрэг	Дунд

Хужиртын нүүрсний орд ашиглах төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг нийт 7 үйл ажиллагаанаас 9 нөлөөллөөр тооцсон. Тэдгээр нөлөөллийн 4 буюу 50% нь “дунд”, 5 буюу 56% нь “их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Үүнээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь нөлөөллийн хувьд дундаас дээш байгаа учир энэ нь төслийн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх нь чухал шаардлагатай болохыг харуулж байна.

Хүснэгт 17. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ		Нийт
		Дунд	Их	
1	Газар шорооны ажил	-	1	1
2	Нүүрс олборлолт	-	1	1
3	Гадаад дотоод овоолго үүсгэх	-	1	1
4	Тээвэрлэлт	1	-	1
5	Засвар үйлчилгээ	1	1	2
6	Шатахуун хадгалах, түгээх	2	-	2
Нийт (тоогоор)		4	5	9
Нийт (%)		44%	56%	100%

### 2.3. Газрын гадарга болон хэвлийд нөлөөлөх байдлын үнэлгээ

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь ил уурхайн талбай (ухаш), далан, овоолго үүсгэх зэргээр газрын гадаргын хэлбэр дүрс, байгалийн тогтцыг өөрчлөх ба уурхайн нийт нөөцийг ашиглах 15 жилийн хугацаанд нийтдээ 627,25 га талбай эвдрэлд орох бөгөөд энхий 5 жилийн хугацаанд 220 га талбай эвдрэлд орно.

Хүснэгт 18. Газрын гадарга болон хэвлийд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Үйл ажиллагаа	Боломжит/Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн үнэлгээ
1	Газрын гадарга болон хэвлий	Нүүрс олборлох	Хөрс хуулалтаас газрын гадарга эвдрэлд өртөх	2-Дунд зэрэг	Их
2	Газрын гадарга болон хэвлий		Хөрс хуулалтаас газрын гадаргын унаган төрх өөрчлөгдөх	2-Дунд зэрэг	Дунд
3	Газрын гадарга болон хэвлий		Тээвэрлэлтийн улмаас газрын гадарга эвдрэлд өртөх, төрх байдал өөрчлөгдөх	2-Дунд зэрэг	Дунд
4	Газрын гадарга болон хэвлий	Гадаад, дотоод овоолго үүсгэх	Гадаад овоолго үүсгэх тухайн талбайн газрын гадаргын үндсэн хэв шинж, төрх байдал дарагдах, өөрчлөгдөх	4-Онц ноцтой	Маш их
5	Газрын гадарга болон хэвлий	Хүнд машин механизмын хөдөлгөөн	Тээвэрлэлтийн үед үүсэх тоос, шорооны улмаас газрын гадарга тоосонд дарагдах, бохирдох	2-Дунд зэрэг	Их
6	Газрын гадарга болон хэвлий		Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга элэгдэлд орох, хэв шинж өөрчлөгдөх	2-Дунд зэрэг	Дунд
7	Газрын гадарга болон хэвлий	Ухаж ачих	Газрын гадаргын унаган төрх өөрчлөгдөх	4-Онц ноцтой	Маш их
8	Газрын гадарга болон хэвлий	Засвар үйлчилгээ	Тос тосолгооны материалын асгаралтаас газрын гадарга бохирдох	4-Онц ноцтой	Их
9	Газрын гадарга болон хэвлий	Уурхайн карьер үүсгэх	Ил уурхайн талбай буюу 209 га талбайн газрын гадарга үндсэн хэв шинжээ алдах	4-Онц ноцтой	Их
10	Газрын гадарга болон хэвлий		Газрын гадаргад хоосон (ухсан) орон зай үүсэх	4-Онц ноцтой	Их

Хужиртын нүүрс олборлох ашиглах төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөллийг нийт 6 үйл ажиллагаанаас 10 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 3 буюу 30% нь “дунд”, 4 буюу 40% нь “их”, 2 буюу 20% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл нь нөлөөллийн хувьд их байгаа учир энэ нь төслийн газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээг сайтар авч хэрэгжүүлэх чухал шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 19. Газрын гадарга болон газрын хэвлийд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ			Нийт
		Дунд	Их	Маш их	
1	Нүүрс олборлолт	2	1	-	3
2	Гадаад овоолго үүсгэх	-	-	1	1
3	Хүнд машин механизмын хөдөлгөөн	1	1	-	2
4	Ухаж ачих	-	-	1	1
5	Засвар үйлчилгээ	-	1	-	1
6	Уурхайн карьер үүсгэх		2	-	2



Нийт (тоогоор)	3	5	2	10
Нийт (%)	30%	50%	20%	100%

#### 2.4. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Хужиртын нүүрсний орд ашиглах төслийн явцад шимт хөрс хуулах, ил уурхайн карьер, овоолго үүсгэх зэрэг уулын бүхий л үйл ажиллагаанаас нийт 627,25 га талбайн хөрс хуулагдаж, үржил шимт хөрс болон ургамлан бүрхэвч зайлуулагдана. Мөн уулын ажлын тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, машин механизмын шатах тослох материалын асгаралт зэргээс хөрсөн бүрхэвч бохирдох эрсдэлтэй. Тухайлбал: Тоног төхөөрөмжийн барилга, газар шорооны ажил

Машин механизмын хөдөлгөөн, техникийн аюулгүй ажиллагаа алдагдах зэргээр хөрсөнд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хүснэгт 20. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Үйл ажиллагаа	Боломжит нөлөөлөл /Болзошгүй	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн үнэлгээ
1	Хөрсөн бүрхэвч	Уурхайн тоног төхөөрөмж суурилуулалтын ажил	Тоног төхөөрөмжийг байрлуулах үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар нь алдагдах	2-Дунд зэрэг	Их
2	Хөрсөн бүрхэвч	Хөрсний гадаад овоолго үүсгэх	Хөрсний гадаад овоолго үүсгэх талбайн хөрс уурхайн ашиглалтын хугацаанд овоолгын дор дарагдах, хөрсний унаган хэв шинж өөрчлөгдөх	3-Ноцтой	Их
4	Хөрсөн бүрхэвч	Хуулсан хөрсийг гадаад овоолго руу тээвэрлэх	Ил уурхайгаас хуулах хөрсийг автосамосвалаар тээвэрлэх бөгөөд хүнд даацын машин механизмын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэж, эвдрэлд орох, сул шороо ихээр үүсэх	2-Дунд зэрэг	Их
5	Хөрсөн бүрхэвч	Жонш тээвэрлэх	баяжуулах үйлдвэрлүү зөөх явцад хүнд даацын машин механизмын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэж, эвдрэлд орох	2-Дунд зэрэг	Их
6	Хөрсөн бүрхэвч	Хөрс хуулалт	хөрсийг хуулах хийгдэж тухайн орчны хөрсөн бүрхэвч гадаргаас зайлуулагдах	4-Онц ноцтой	Маш их
7	Хөрсөн бүрхэвч	Хүнд даацын машин механизмын	Тээврийн машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс бохирдуулах	3-Ноцтой	Дунд
8	Хөрсөн бүрхэвч	хөдөлгөөн	Тээврийн хөдөлгөөнөөс хөрсний элэгдэл үүсэх	2-Дунд зэрэг	Дунд
10	Хөрсөн бүрхэвч	Засвар үйлчилгээ	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдох	3-Ноцтой	Их

Хужиртын нүүрсний орд ашиглах төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг нийт 7 үйл ажиллагаанаас 8 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 2 буюу 25% нь “дунд”, 5 буюу 63% нь “их” 1 буюу 13% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд

төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл нь нөлөөллийн хувьд их байгаа учир энэ нь төслийн зүгээс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээг сайтар авч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 21. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ			Нийт
		Бага	Дунд	Их	
1	Уурхайн тоног төхөөрөмж суурилуулалтын ажил			1	1
2	Хөрсний гадаад овоолго үүсгэх			1	1
3	Хуулсан хөрсийг гадаад овоолго руу тээвэрлэх			1	1
4	Жонш тээвэрлэх			1	1
5	Хөрс хуулалт				1
6	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн		2		2
7	Засвар үйлчилгээ			1	1
Нийт (тоогоор)			2	5	8
Нийт (%)		0%	25%	63%	100%

## 2.5. Усан орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Хужиртын ордод 2015 онд гидрогеологи, инженер геологийн судалгааны ажлыг “Илч Хужирт” ХХК хийж гүйцэтгэсэн байна. Тус судалгааны ажлын тайлангийн үзүүлэлтүүдийг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 22. Хужиртын ордын геологийн үзүүлэлт

д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тооцооны утгууд
1	Уст давхаргын зузаан, m	м	26
2	Шүүрэлтийн итгэлцүүр, к	м/хоног	3.44
3	Цооногийн ундарга	л/сек	2.3-6.4
4	Ус дамжуулалтын итгэлцүүр, км	м <sup>2</sup> /хоног	1.32*10 <sup>2</sup>
5	Түвшин дамжуулалтын итгэлцүүр, ау	м <sup>2</sup> /хоног	5.31*10 <sup>3</sup>
6	Нөлөөллийн радиус, R	м	1784.1
7	Газар доорх усны түвшин, Н	м	9.5-25.0
8	Газар доорх усны түвшин бууруулах хэмжээ, S	м	94.3

Ил уурхайд орж ирэх усны тооцоо: Хужиртын ордыг ил аргаар ашиглах нөхцөлд уурхайд орж ирэх усны хэмжээг гидродинамикийн арга дээр тулгуурлан “Их худгийн” томъёогоор тодорхойлбол:  $Q = 1.36 \cdot k \cdot m \cdot 2LgRr_0, \text{м}^3/\text{хоног}$

Энд:

k – шүүрэлтийн итгэлцүүр, м/хоног

m – уст давхаргын зузаан, м

R – депресс хүрэх нөлөөллийн радиус / $R = 1.5 \sqrt{ay \cdot T} = 9107.4 \text{ м}$ /

a – ус дамжуулалтын итгэлцүүр, м<sup>2</sup>/хоног / $ay = 1.01 \cdot 10^5 \text{ м}^2/\text{хоног}$ /

T – ашиглалтын хугацаа, хоног

r<sub>0</sub>- уурхайн радиус, уурхайн талбайн радиусыг тодорхойлохдоо урт, өргөний харьцаагаар авах ба урт нь өргөнөөсөө 3 буюу түүнээс дээш урт нөхцөлд дараах томъёогоор бодно.  $r_0 = P/2\pi$ ,

Уурхайн ашиглалтын эхний жилд хоногт 346.53 м<sup>3</sup>/хоног ус орж ирэх бол уурхай төслийн гүнд хүрэхэд уурхайд хоногт 754.74 м<sup>3</sup>/хоног ус шүүрэн орж ирэхээр байна.

Уурхайд орж ирэх хур тунадас, болзошгүй үерийн усны тооцоо: Эх газрын эрс тэс уур амьсгалтай, зундаа +35 - +40°C, өвөлдөө -30 -35°C хүйтэрдэг. Хур тунадасны хэмжээ жилд 100-500 мм хүрэх ба үүний 60-70% нь 7-8-н сард ордог. Цаг уурын мэдээг аймгийн болон бусад ойролцоо сумдын цаг уурын мэдээнд тулгуурлан гаргадаг. Цасан бүрхүүлийн дундаж зузаан 15-25 см хүрнэ. Агаарын чийгшил 35-70%-ийн хооронд хэлбэлзэнэ. 3-5 сард их салхилах ба ихэвчлэн баруун хойноос чиглэлтэй, салхины дундаж хурд 4-9 м/сек байна. Нэг хоногт буух хур тунадасны дундаж хэмжээ 0.00082 м/хоног байна. Ил уурхайд хур тунадас, болзошгүй үерээс ус орж ирнэ. Энэ үед усны хоногт орж ирэх дундаж хэмжээ:

$$Q = Wt$$

Энд:

W- ил уурхайд хоногт орох хур тунадасны хэмжээ (болзошгүй үерээс байж болно), м

$$W = F \cdot h_1 \cdot n, \text{ м}^2$$

F- ил уурхайн талбай, м<sup>2</sup>

h<sub>1</sub>- ил уурхайд хоногт буух хамгийн их хур тунадас, м/хон. 0.061 м/хон

n- уурхайд буух хур тунадасны хэмжээтэй харьцуулсан урсцын итгэлцүүр. Энэ итгэлцүүр нь 0.6-0.7 байдаг. Тооцоонд 0.6-өөр авлаа.

t- ил уурхайн усыг тасралтгүй 24 цагаар шавхах, цаг

Уурхайн ашиглалтын эхний жилд хоногт 1.15 м<sup>3</sup>/хоног ус орж ирэх бол уурхай төслийн гүнд хүрэхэд уурхайд хоногт 16.74 м<sup>3</sup>/хоног хур тунадас болон болзошгүй үерийн ус орж ирэхээр байна.

Хүснэгт 23.

Ус шүүрэлтийн тооцоо

№	Үзүүлэлтүүд	нэгж	2024 онд
1	Шүүрэлтийн итгэлцүүр	к	3.44
2	Уст үеийн зузаан	m	26
3	Нөлөөллийн радиус	R	673.4
4	Нөлөөллийн радиус	R0	838.7
5	Ил уурхайн талбайн радиус	r	165.4
6	Түрэлтийн дундаж хэмжээ	H	12.0
7	Усны түвшин бууруулах хэмжээ	S	35.6
8	Логарифмын утга	log	0.705
9	Хоногт орж ирэх усны хэмжээ	Q, м <sup>3</sup> /хон	346.53
10	Цагт орж ирэх усны хэмжээ	Q, м <sup>3</sup> /цаг	14.44
11	Секундэд орж ирэх усны хэмжээ	Q, л/сек	4.01
12	Жилд орж ирэх усны хэмжээ	Q, м <sup>3</sup> /жил	126,483

Хүснэгт 24.

Ус шүүрэлтийн тооцоо ашиглалтын жилээр

№	Үзүүлэлтүүд	нэгж	2024 онд
1	Уурхайн талбай	F	67,158
2	Хур тунадасны хэмжээ	h <sub>1</sub> , м/жил	0.00082
3	Урсацын итгэлцүүр	n	0.5
4	Хугацаа	t	24.0
5	Хоногт орж ирэх усны хэмжээ	Q, м <sup>3</sup> /хон	1.15
6	Цагт орж ирэх усны хэмжээ	Q, м <sup>3</sup> /цаг	0.05
7	Хоногт орж ирэх усны хэмжээ	Q, л/сек	0.01
8	Жилд орж ирэх усны хэмжээ	Q, м <sup>3</sup> /жил	34.42

### Уурхайд орж ирэх усыг зайлуулах, мөргөцгийг хуурайшуулах ажил

Уурхайн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, найдвартай явуулахад ил уурхайд орж ирэх усыг зайлуулах, нүүрсний үе, давхраас, уурхайн мөргөцгийг хуурайшуулах, шүүрүүлэх ажлыг зайлшгүй гүйцэтгэнэ. Уурхайд орж ирэх усыг Дренажийн сувгаар уурхайн мөргөцгийн хамгийн

нам дор хэсэгт хуримтлуулан ус өргөх шахуургын (насос) тусламжтайгаар ус таталтыг явуулна. Ус шүүрүүлэлтэд ажиллах тоног төхөөрөмжийн хувьд дизель насос ашиглахаар тооцов.

Уурхайд орж ирэх усыг уурхай дотор зумпф байрлуулж шавхах аргаар зайлуулна. Уурхайд орж ирэх гүний болон гадаргын усны хэмжээ ашиглалтын эхний жилд 14.45 м<sup>3</sup>/цаг байна.

Уурхайгаас шүүрүүлэх усны хэмжээ жилд дунджаар 25.0 м<sup>3</sup>/цаг буюу харьцангуй бага байгаа бөгөөд шүүрлийн усыг уурхайн зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашиглана. Уурхайд ЦНСк-60/80 төрлийн шахуурга 1 ширхэг ажиллахаар байна. Шахуургын техникийн үзүүлэлтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Унд, ахуйн ус ашиглалтын тооцоо: Уурхай нь жилд 353 хоног, 2 ээлжээр 12 цагийн горимоор 154-190 хүн ажиллана. 1 гүний худаг, ундарга нь 2л/с буюу 172.8 м<sup>3</sup>/хон

Шүүрлийн усны хэмжээ эхний жил 346.53 м<sup>3</sup>/хон

БОНХАЖСайдын А/301 дугаар тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оор тооцоход:

- Унд ахуйд 190хүн х 150л/хон= 28.5 м<sup>3</sup>/хон ус (10.060.5 м<sup>3</sup>/жил)
- Зам талбайн усалгаанд 38 мян.м<sup>2</sup>\*2л\*30хон/180хон=12.6 м<sup>3</sup>/хон ус (2.280 м<sup>3</sup>/жил)

Нийт 41.1 м<sup>3</sup>/хон (12,340.5 м<sup>3</sup>/жил) ус шаардагдана.

Төсөл хэрэгжүүлэхэд унд ахуйн хэрэглээнд шаардагдах 28.5 м<sup>3</sup>/хон усыг 2л/с (172.8 м<sup>3</sup>/хон) ундрагатай өөрийн эзэмшлийн худагас, зам талбайн усалгаанд шаардагдах 12.6 м<sup>3</sup>/хон усыг уурхайн шүүрлийн усаар хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

Хүснэгт 25. Ус орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Үйл ажиллагаа	Боломжит/ Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн үнэлгээ
1	Гадаргын ус	Ашиглахгүй	Хужиртын голын эргээс 1,5 км зайд олборлолт явагдах бөгөөд усны шүүрэл гадаргын уснаас үүсэх	3-Ноцтой	Дунд
2	Шүүрэлтийн ус	Тоосжилт бууруулах үйл ажиллагаа	Орчны тоосжилт бууруулахад ус ашигласны улмаас усны нөөц хомсдох	1-Хөнгөн	Бага
3	Газрын доорх ус	Шатахуун хадгалах, түгээх	Агаар солилцооны бүсийн шинж нь бохирдуулах бодисын тоо хэмжээ, чанарын өөрчлөлт хор нөлөөний үйлчлэх байдал зэргийг тогтооход чухал. Өөрөөр хэлбэл бохирдуулах бодисын тоо хэмжээ, чанар нь биохимийн урвалаар өөр бодис болж хувирах, шингээх биет болох, уурших, механик шүүлтүүрээр шүүгдэх, саармагжих, химийн урвалд орох, сарних гэх мэт үйл явцаар өөрчлөгдөж усан сан бүхий газрыг бохирдуулж болзошгүй	3-Ноцтой	Дунд

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Газрын доорх ус	Засвар үйлчилгээ	Слох материал, нефтийн бүтээгдэхүүн бодис алдагдах, хур тунадас болон заар угаагдан усан орчин бохирдуулах	3-Ноцтой	Дунд
5	Газрын доорх ус	Уурхайн ухаш байгуулах, далан байгуулах	Уурхайн ухаш үүсэх, далан байгуулах, суваг шуудуу хатах, хөрс эвдрэлд оруулах зэргээр газрын гадаргын хэлбэр дүрсийг өөрчилснөөр гадаргын урсцын байгалийн унаган тогтоц өөрчлөгдөх	3-Ноцтой	Дунд
6	Газрын доорх ус	Тэжээгдэлийн мужаар дамжин газар доорх ус нь бохирдох	Хур борооны гаралтай эсвэл бусад эх үүсвэр буюу бохирдсон усны шүүрэлт, чөлөөт нэвчилтээр шилжиж ирэх ус тэжээгдэлийн мужаар дамжин газар доорх усыг бохирдох	3-Ноцтой	Дунд

Хужиртын нүүрсний орд ашиглах төслөөс гадаргын болон усанд үзүүлэх нөлөөллийг нийт 6 үйл ажиллагааны 6 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 2 буюу 33% нь “бага”, 4 буюу 67 % нь “дунд” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс усан орчинд үзүүлэх нөлөөлөл нь нөлөөллийн хувьд дунд зэрэг байна.

Хүснэгт 26. Газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ		Нийт
		Бага	Дунд	
1	Тоосжилт бууруулах үйл ажиллагаа	1		1
2	Шатахуун хадгалах, түгээх		1	1
3	Засвар үйлчилгээ		1	1
4	Уурхайн ухаш байгуулах, далан байгуулах	1	1	2
5	Тэжээгдэлийн мужаар дамжин газар доорх ус нь бохирдох		1	1
Нийт (тоогоор)		2	4	6
Нийт (%)		33%	67%	100%

## 2.6. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүнд:

- ✚ Талбайн үржил шимт хөрс хуулагдсанаар эдгээр талбайн ургамлан нөмрөг зайлуулагдах, устгах
- ✚ Машин механизмын хөдөлгөөн, олон салаа зам гаргах зэргээр ургамлан нөмрөг талхлагдаж, доройтох
- ✚ Тоосжилтын улмаас ургамлан нөмрөг доройтох

Хүснэгт 27. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Үйл ажиллагаа	Боломжит/Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн үнэлгээ
1	Уурхайн эдэлбэр газарт баяжуулах тоног төхөөрөмж байгуулах	Уурхайн үйл ажиллагаанаас газрын гадарга эвдрэлд орох ба тухайн талбайн ургамлан нөмрөг зайлуулагдах, зарим нь устгах	3-Ноцтой	Их
2	Хөрс хуулалт	Хөрс хуулалтын явцад үүсэх тоос, машин техникээс ялгарах утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчны 15-50м зай доторх ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвхтэй туяа шингээлтийг бууруулах	2-Дунд зэрэг	Бага
3	Хөрс, элсний овоолго үүсгэх	Шимт хөрс, хоосон чулуулгийн овоолго байгуулах талбайн	2-Дунд зэрэг	Дунд

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		ургамлан нөмрөг дарагдаж, үндсэн хэв шинж, шинж чанараа алдах		
4	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдах, доройтох	2-Дунд зэрэг	Бага
5	Дэд бүтцийн барилга (харуулын байр г.м) байгууламж байгуулах	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон байнгын газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх	2-Дунд зэрэг	Бага
6	Шатахуун хадгалах, түгээх	Асгаралт үүссэнээр ургамлан нөмрөг бохирдох	3-Ноцтой	Дунд
7	Засвар үйлчилгээ	Шатах тослох материалын асгаралт үүсч ургамлан нөмрөгийг бохирдуулах	3-Ноцтой	Дунд

Хужиртын нүүрсний орд ашиглах төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг нийт 7 үйл ажиллагаанаас 7 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 3 буюу 43% нь “бага”, 3 буюу 43% нь “дунд”, 1 буюу 14% нь “их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл нь дунд зэрэг байна.

Хүснэгт 28. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ			Нийт
		Бага	Дунд	Их	
1	Уурхайн эдэлбэр газарт баяжуулах тоног төхөөрөмж байгуулах			1	1
2	Хөрс хуулалт	1			1
3	Хөрс, элсний овоолго үүсгэх		1		1
4	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн	1			1
5	Дэд бүтцийн барилга (харуулын байр г.м) байгууламж байгуулах	1			1
6	Шатахуун хадгалах, түгээх		1		1
7	Засвар үйлчилгээ		1		1
Нийт (тоогоор)		3	3	1	7
Нийт (%)		43%	43%	14%	100%

## 2.7. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ

Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс амьтны аймагт нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүнд:

- ✚ Барилга байгууламжийн ажлын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс зэрлэг амьтад үргэн дайжих
- ✚ Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох
- ✚ Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд орох
- ✚ Уурхайн ухацд зэрлэг амьтад, мал унаж бэртэх
- ✚ Зэрлэг амьтдын тархац нутаг хумигдах, амьдрах орчны хуваагдал үүсэх зэргээр нөлөөлөл үзүүлж болзошгүй байна.

Хүснэгт 29. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Үйл ажиллагаа	Боломжит/ Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн үнэлгээ
1	Дэд бүтцийн барилга угсралт	Тоосжилтын улмаас амьдрах орчин доройтох, амьтад дайжих Амьдрах орчны унаган төрх, хэв шинж алдагдах	1-Хөнгөн	Бага
2			2-Дунд зэрэг	Бага
3	Хөрсний гадаад овоолго үүсгэх	Амьдрах орчны хэв шинж алдагдах Амьтад амьдрах орчноосоо дайжих	2-Дунд зэрэг	Бага
4			2-Дунд зэрэг	Бага
5	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн	Талбай орчмын зарим жижиг хөхтөн амьтад машин механизмд дайруулах Амьтад амьдрах орчноосоо дайжих	3-Ноцтой	Дунд
6			2-Дунд зэрэг	Бага
7	Хөрс хуулалт	Хөрсөнд үүрлэн амьдрагч жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах Хөрсөнд үүрлэн амьдрагч жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүд уурхайн үйл ажиллагаанд өртөх, устгах	2-Дунд зэрэг	Бага
8			2-Дунд зэрэг	Бага

Хужиртын нүүрсний орд ашиглах төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг нийт 4 үйл ажиллагаанаас 8 нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 7 буюу 87% нь “бага”, 1 буюу 13% нь “дунд” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл нь бага байна.

Хүснэгт 30. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ		Нийт
		Бага	Дунд	
1	Дэд бүтцийн барилга угсралт	2		4
2	Хөрсний гадаад овоолго үүсгэх	2		2
3	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн	1	1	2
6	Хөрс хуулалт	2		2
Нийт (тоогоор)		7	1	8
Нийт (%)		87%	13%	100%

### Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийг матрицын үнэлгээний арга дээр тулгуурлан Олон улсын туршлагад өргөн хэрэглэгдэж буй нөлөөллийн үнэлгээний үр дагавар болон тохиолдох магадлалын шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан тодорхойлсон.

Хужиртын нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас 48 сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэхээр байна. Үүний 12 буюу 25% нь бага, 17 буюу 35% нь дунд, 16 буюу 33% нь их, 3 буюу 7% нь маш их гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна.

Хүснэгт 31. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгдсэн дүн

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ				Нийт
		Бага	Дунд	Их	Маш их	
1	Агаарын чанар	0	4	5	0	9
2	Амьтны аймаг	7	1			8
3	Гадаргын болон газрын доорх ус	2	4	0		6
4	Газрын гадарга болон хэвлий	0	3	5	2	10
5	Ургамлан нөмрөг	3	3	1		7

6	Хөрсөн бүрхэвч	0	2	5	1	8
Нийт (тоогоор)		12	17	16	3	48
Нийт (%)		25%	35%	33%	7%	100%

## 2.8. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ

Хүснэгт 32.

Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн	Төслөөс учирч болзошгүй нөлөөлөл	
	Эерэг нөлөөлөл	Сөрөг нөлөөлөл
Нутгийн иргэдэд үзүүлж болзошгүй нөлөөлөл		
Ажил эрхлэлт, амьжиргаа	+	
Шилжилт хөдөлгөөн	+	+
Нүүлгэн шилжүүлэлт		+
Эдийн засгийн хөгжилд гарч болох нөлөөлөл		
Сэлэнгэ аймаг	+	
Түшиг сум	+	
Дэд бүтэц		
Сэлэнгэ аймаг	+	
Түшиг сум	+	+
Соёлын өвд учирч болзошгүй нөлөөлөл		
Археологийн дурсгал	+	+
Түүх соёлын дурсгалт газар, ТХН		+

Нийгэм эдийн засагт учирч болзошгүй нөлөөллийг урьдчилан тооцоход эдийн засаг, дэд бүтцийн салбарт эерэг өөрчлөлт, харин нутгийн иргэд, соёлын өвд эерэг, сөрөг нөлөөлөл аль аль нь гарч болзошгүй боловч нэгдсэн дүнгийн хувьд төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл их байна.

Хужиртын нүүрсний орд ашиглалтын 15 жилийн хугацаанд улс орон нутгийн төсөвт нийтдээ 9 төрлийн татвар төлбөр төлж байна. Нийт 15 жилийн хугацаанд улс орон нутгийн төсөвт 96.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр байна. Татвар төлбөр нь нийт үйл ажиллагааны зардлын 20%-ийг эзэлж байна. Дотор нь авч үзвэл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нийт татвар төлбөрийн 33%, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 36%, бусад татвар төлбөрүүд үлдсэн хувийг бүрдүүлж байна.

- ✚ Ажил эрхлэлт нэмэгдэх
- ✚ Уурхайд бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлснээр орлого нэмэгдэх, иргэдийн амьжиргаа сайжрах
- ✚ Сумын орлогын эх үүсвэр бэхжих
- ✚ Бизнес хөгжихөд таатай орчин бүрдэнэ
- ✚ Хууль бусаар буюу гар аргаар ашигт малтмал олборлох асуудал цэгцрэх

Харин төсөл хэрэгжих үед тухайн орон нутагт эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөтэй хэдий ч төсөл хаагдсаны дараа тухайн орон нутгийн хэмжээнд /сум, баг/ эдийн засгийн тогтворгүй байдал үүсэж болзошгүй.

Хүснэгт 33.

Уурхайн нөлөөллийн бүсэд хамрагдах өрхүүд

№	Нөлөөллийн бүс	Түшиг сум Хужирт баг
Нөлөөллийн бүс		
1	Малчин өрхийн тоо	6
2	Малчин өрхийн өвөлжөө	6
3	Хүн амын тоо	17
4	Малын тоо	3341
Хүчтэй нөлөөллийн бүс (0-1000 м)		
1	Малчин өрхийн тоо	2



Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2	Малчин өрхийн өвөлжөө	2
3	Хүн амын тоо	7
4	Малын тоо	1388
Дунд нөлөөллийн бүс (1001-2500 м)		
1	Малчин өрхийн тоо	2
2	Малчин өрхийн өвөлжөө	2
3	Хүн амын тоо	6
4	Малын тоо	1490
Сул нөлөөллийн бүс (2501-5000 м)		
1	Малчин өрхийн тоо	2
2	Малчин өрхийн өвөлжөө	2
3	Хүн амын тоо	4
4	Малын тоо	463

### Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний дүгнэлт

Хужиртын нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас уурхайн ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нийт 31 нөлөөллийг тооцов. Тэдгээр нөлөөллүүдийн 14 буюу 45% нь бага, 17 буюу 55% нь дунд зэргийн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна.

*Хүснэгт 34. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт*

Эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөө	Нөлөөллийн үнэлгээ		Нийт
	Бага	Дунд	
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх дам нөлөө	7	12	19
Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл	2	4	6
Уурхайн үйлчилгээнээс ажилчдад үзүүлэх нөлөөлөл	5	1	6
Нийт (тоогоор)	14	17	31
Нийт (хувиар)	45%	55%	100%

### 2.9. Түүх соёлын өвд үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбайд 1 ширхэг археологийн олдвор байгаа бөгөөд тухай олдворын нарийн шинжилгээг хийж гүйцэтгэн авран хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Авран хамгаалах арга хэмжээний чиглэл, зардал, хариуцах ажилтан, арга хэмжээ авах арга аргачлал, баримтлах хууль эрх зүй, стандартыг БОМТ-ны арга хэмжээний холбогдох хэсэгт тусгав.

## **ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төмөрлөгийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүллээ.

БОМТ нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Энэхүү төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай буюу байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулж байх шаардлагатай. БОМТ-ний тухайн жилийн хяналт, үзлэгээр төслийн болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх шаардлагатай.

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

*Хүснэгт 35. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Агаар</b>									
1	Нүүрс олборлох талбайн хөрс хуулах болон газар шорооны ажлын үед тоосжилт үүсэх ба тоосжилт нь төсөл хэрэгжих талбай, түүний ойр орчмын нутаг дэвсгэрийн агаарын чанарт нөлөөлөх	Төсөлд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийг оношилгоонд оруулах	Төсөлд ашиглаж буй бүх тээврийн хэрэгслүүд	Ширхэг	33.0	20	660.0	2024 онд, 1 удаа	Байгаль хамгаалах тухай хууль Агаарын тухай хууль, MNS ISO 14064.1:2015 MNS 5013:2009 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 4585:2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага
		Тоосжилт, агаарын чанарын хяналтыг тогтмол хийж байх;	Төслийн талбай, нөлөөллийн бүс	Удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав			2024 онд, 2 удаа	
		Төслийн талбайд хурдны хязгаар баримтлах	Дотоод болон гадаад тээврийн зам	Тогтмол	Дотоод төлөвлөгөөгөөр			Өдөр бүр	
2	Эвдэрсэн газар болон сул хөрстэй зам, талбайгаас тоос босох, үүссэн тоосжилт салхиар дамжин тухайн орчинд байнга ажиллаж, амьдарч буй хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Төслийн зам талбайг услах	Дотоод болон гадаад тээврийн зам	Удаа	Дотоод төлөвлөгөө гөөр	Өдөр бүр	Төслийн зам талбайг услах	Дотоод болон гадаад тээврийн зам	
		Хөрс хуулалтаас гарсан овоолгын гадаргууг ургамалжуулах, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах;	Хөрсний овоолго	м <sup>2</sup>	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгав			2024 онд, 1 удаа	
		Ашиглах замыг засаж сайжруулах, шаардлагатай газрыг хайрган юмуу хатуу хучилттай болгох;	Дотоод болон гадаад тээврийн зам	км	Дотоод төлөвлөгөөгөөр			2024 онд, 1 удаа	
5	Ажиллагсад мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвдөх (тоосжилт, дуу шуугиан)	Ажиллагсдыг эмчийн иж бүрэн үзлэг шинжилгээнд хамруулах	Төслийн бүх ажиллагсад	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан.			2024 онд		
<b>Газрын хэвлий</b>									

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Нүүрс олборлох талбайн хөрсийг хуулах, газрыг ухаж эвдэх, өнгөн хөрс, хурдас чулуулгийн овоолго хийх, нүх карьер үүсгэх зэргээс газрын хэвлий эвдрэх, гадаргын тогтоц, хэлбэр төрх өөрчлөгдөх;	Шимт хөрсийг стандартын дагуу хуулах, нөхөн сэргээх, хадгалах	Нөхөн сэргээх шаардлагатай ашиглалтад өртсөн газрууд	Нөхөн сэргээлтийн зардалд тусгасан.				2024 онд	MNS 5915:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал БОНХ-ийн сайд 2015 А-138 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
Гадаргын болон газрын доорх усны нөөц									
1	Ахуйн бохир ус, хог хаягдлаар хөрсний болон гүний ус бохирдохоос сэргийлэх	Ахуйн бохирыг гэрээ байгуулан зөөлгөж шилжүүлэх, сумын бохир зайлуулдаг цэг дээр нэмэлтбохир зайлуулах цэг байгуулах	Уурхайн талбай	Дотоод төлөвлөгөөгөөр				2024 онд	“Усны тухай” хууль, 2012 он; “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хууль, 2012 он; MNS 0900:2018 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
2	Түлш шатахуун, шатах тослох материал, ахуйн бохир ус асгарч алдагдах тохиолдолд бага гүнд орших уст давхаргын усыг бохирдуулах;	Авто зогсоол, ШТС, засварын цехийн талбайг бохирдохоос сэргийлж хайрга, бетоноор хучих	ШТС, засварын газар, зогсоол	м <sup>2</sup>	5,000.0	1	5,000.0		
3	Усны хяналтгүй хэрэглээ	Усны эх үүсвэрийг тоолууржуулах, бүртгэлжүүлэх	Усны эх үүсвэр	ш	370.0	2	740.0		
Хөрсөн бүрхэвч									
1	Нүүрс олборлох үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвч хүчтэй	Уурхайн орчны эвдэрсэн хөрсийг засч тэгшлэх,	Төслийн талбай	м <sup>2</sup>	50.0	100	5,000.0	2024 онд	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	эвдрэлд орох; уурхай орчмын хөрс зам, тээврийн үйл ажиллагаанд өртөж элэгдэл, эвдрэлд орох, барилга байгууламжийн доорх хөрсний өнгөн үе давхарга устах	техникийн нөхөн сэргээлт хийх; Барилга байгууламж байгуулахад өртөж эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх, ургамалжуулах							шимт хөрс хуулалт, хадгалалт  MNS 5859:2008 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”
2	Хөрс, газрын гадарга хатуу хог хаягдлаар бохирдох	Төслийн талбайд хог хаягдлыг ангилах сав байршуулах	Төслийн талбайд	Хог хаягдлын хэсэгт оруулав				2024 онд	Хог хаягдлын тухай хууль
3	Олон салаа зам гаргаж, хөрс газрын гадарга эвдэх	Олон салаа зам гаргахаас сэргийлэх, тэмдэгжүүлэх	Төслийн талбайд	ш	3	50.0	150.0	2024 онд	MNS 4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
Ургамлан нөмрөг									
1	Олборлолт явуулах болон ажиллагсдын тосгоны барилга байгууламж барьж байгуулах явцад ургамлан нөмрөг гэмтэх, устах;	Эвдрэл, доройтолд ороогүй болон ургамалжуулсан газруудад машин, техник орохыг хязгаарлах, олон салаа зам гаргахгүй байх, уурхайн замыг тэмдэгжүүлэх;	Төслийн талбайд	Хөрс хамгаалах төлөвлөгөөнд тусгав				2024 онд	MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Монгол Улсын стандарт MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт Техникийн ерөнхий шаардлага, MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
2	Уурхайн үндсэн үйл ажиллагаа болон ажилчид ургамлан нөмрөгийг талхлах, гэмтээх, устах;	Нэн ховор, ховор ургамлыг таних, хамгаалах, ургамал нөмрөг, газрын гадарга хамгаалах талаар сургалт хийх	Төслийн ажилчид	удаа	1	500.0	500.0		
Амьтны аймаг									

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарах дуу чимээнээс тухайн нутаг дэвсгэрийн амьтад дайжих	Шаардлагагүй үед дуут дохио өгөхгүй байх, дуут дохио өгөхийг хориглосон тэмдэг байршуулах	Төслийн талбайн орчимд	ш	50.0	5	250.0	2024 онд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралт
2	Уурхайн ухаш, овоолгоруу амьтан орж ирэх	Төслийн ашиглалтын талбайг хашаажуулах	Төслийн талбай	Дотоод төлөвлөгөөгөөр			2024 онд		
<b>Нийт= 12,300.0 мян.төг</b>									

### 3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад тогтоол зааврын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа байгууллага нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын стандарт /MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008 /-ын дагуу заавал хийсэн байх үүрэгтэй.

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэнд оруулах чиглэл, цаашид ашиглах хэлбэрийг зөв тодорхойлсоноор нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Хужиртын нүүрсний уурхай төсөл нь ашиглалтын эхний 4 жилд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй, овоолго, ухаш үүсгэжтээвэртэй ашиглалтын системээр олборлолт явагдана. 5 дахь жилээс ТНС ажил эхлэнэ. Эвдэрсэн газрыг хөдөө аж ахуйн чиглэлээр (бэлчээрийн чиглэлээр) нөхөн сэргээлтийг хийнэ гэж уурхайн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан бөгөөд бид хөрс хуулах, хөрсний овоолго үүсгэх, хаягдлын овоолго үүсгэх, уурхайн дотоод тээврийн зам тавих, уурхайн бариилга байгууламж барих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх бөгөөд уг ажлын хүрээнд шимт хөрс хуулалт хийгдэнэ.

Мөн хуулсан шимт хөрсийг шимт хөрсний овоолгод нэгдсэн байдлаар овоолж үржил шимийг нь хадгалах зорилгоор усалгаа, бордолт хийнэ.

### Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ

2024 онд уурхайн ашиглалтын явцад олборлолт болоод барилга байгууламж, зам талбайд нийтдээ 25.5 га эвдрэлд өртөнө. Олборлолтод өртөх талбайн үржил шимт хөрсийг урьдчилан 0.3-0.7 м-ийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах бөгөөд ордын ашиглалтын явцад болон ашиглаж дууссаны дараагаар хийгдэх нөхөн сэргээлтэд ашиглана. Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд нөхөн сэргээлтэд ойролцоогоор 10,000.0 мян.төг зарцуулагдана гэж тооцлоо.

Хүснэгт 36.

Нөхөн сэргээлтээр хийх ажлын хэмжээ

№	Эвдрэл үүсэх талбай	Нийт хэмжээ, га	2024 онд хийгдэх ажил, га	Шимт хөрсний хэмжээ, м <sup>3</sup>
1	Ил уурхай	579.70	13.5	40 500
2	Хөрсний түр овоолго	20.00	2	6 000
3	Зам талбай	18.50	8	24 000
4	Барилга байгууламж	2.50	2	6 000
	<b>Дүн</b>	<b>620.7</b>	<b>25.5</b>	<b>76 500</b>

Ордын уул геологи, уул техникийн нөхцөлөөс хамааруулан гадаад овоолготой ашиглалтын системээр олборлолтын ажлыг явуулна. Хөрсний гадаад овоолго нь уурхайгаас баруун хойд зүгт дунджаар 1,6 км зайд байрлана. Хужиртын нүүрсний ордын хөрсний овоолгын тээврийн зурвасын өргөн 20 м, доголын налуу 35 градус ба овоолгын өндөр 50 м, 2 ярустай, овоолгын нийт хажуугийн өнцөг 30 градус байна. Хөрсний овоолгын хэлбэржүүлэлт болон уурхайн туслах ажлуудыг бульдозерын тусламжтай гүйцэтгэнэ.

### 3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагааны үед хэрэгжүүлэх Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлтийг төслийн БОННУ-ний тайланд тусгаагүй тул 2024 онд цаашид хэрэгжүүлэх Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн судалгаа, төлөвлөгөөг хийж гүйцэтгэнэ. Уг судалгааг

мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх бөгөөд урт хугацааны менежментийг хэрэгжүүлэх боломжит газрыг сонгуулан, стратеги төлөвлөгөөг гаргуулан орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын саналыг тусган боловсруулуулна. Тухайн ажлын өртгийг 10,000.0 мян.төг байхаар төсөвлөв.

### 3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн талбайд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох үйл ажиллагаа 2024 онд хийгдэхгүй.

### 3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн талбайд 1 ширхэг археологийн олдвор байгаа бөгөөд тухай олдворын нарийн шинжилгээг хийж гүйцэтгэн авран хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Авран хамгаалах арга хэмжээний чиглэл, зардал, хариуцах ажилтан, арга хэмжээ авах арга аргачлал, баримтлах хууль эрх зүй, стандартыг баримтлан мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж арга хэмжээ авч ажиллана.

### 3.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг
1.	Төслийн талбайн гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	2024 онд	Байгууллага хоорондын гэрээгээр
2.	Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг хийж гүйцэтгэх	2024 онд	Дотоод төлөвлөлтөөр
3.	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	2024 онд	Дотоод төлөвлөлтөөр
4.	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах	2024 онд	Дотоод төлөвлөлтөөр
5.	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	2024 онд	2,200.0 мян.төг
	<b>Нийт зардал</b>		2,200.0 мян.төг

### 3.7. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Чулуун нүүрсний ордыг ашиглах үйл ажиллагаандаа химийн тэсрэх бодис болон шатах тослох материал ашиглана.

Тэсэлгээний ажлыг 14 хоногт 1 удаа явуулна. Нийт тэсрэх бодисын 40% ANFO буюу энгийн тэсрэх бодис, үлдсэн 60%-д эмульсийн тэсрэх бодис ашиглана. Тэсрэх бодисын хувийн зарцуулалт хөрсөнд 0.50 кг/м<sup>3</sup>, нүүрсэнд 0.45 кг/м<sup>3</sup> тус тус байна. Тэсэлгээний хэрэгсэлд цооногийн детенатор, гадаргуун детенатор, өдөөгч, гал дамжуулах утас /ОША/ зэргийг ашиглана.

### 3.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Илч хужирт” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас ахуйн хатуу болон шингэн хаягдал ялгарах бөгөөд хатуу хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломж бүхий хогийн сав байршуулна. Мөн ариун цэврийн байгууламжийг БОАЖСайдын 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар



албан даалгаврын 4 дэх хэсэгт заасны дагуу соруулдаг ариун цэврийн байгууламж суурьлуулна. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хогийн савнууд байрлуулахаар жилдээ 2,500.0 мянган төгрөг тусгасан бөгөөд үүнээс бусад зардлуудыг байгууллага хоорондын гэрээгээр явуулна.

### 3.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Нүүрсний орд ашиглах төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрт авч хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд уг ажлыг хийж гүйцэтгэхэд удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг заавал төлөвлөх шаардлагатай.

Хүснэгт 37. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	2024 онд	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	2024 онд	1,000.0
3.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Сэлэнгэ аймгийн ЗДТГ-т хүргэн өгч байх	Жил бүрийн 10-р сард	Дотоод төлөвлөлтөөр
4.	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	2024 онд	2,000.0
5.	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 <sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	2024 онд	10,000.0
6.	Төслийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах судалгааг хийж гүйцэтгэх	2024 онд	Дотоод төлөвлөлтөөр
	<b>Нийт зардал</b>		13,000.0 мян.төг

### 3.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар нүүрсний ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 04-дүгээр сарын 10 ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 38.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ явуулах арга хэлбэр, хэрэглэх багаж төхөөрөмж	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
<b>Агаарын чанар</b>					
Тоосжилт (PM <sub>10</sub> , TSP, PM <sub>2.5</sub> ) Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ -Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин) -Бохирдлын цэгэн эх үүсвэр (SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO)	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн байршил (уурхайн карьер, дотоод тээврийн зам,кемп)	Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд 2 удаа	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн байршил нөлөөллийн төвшин зэрэгт тулгуурлан уурхайн орчим төлөөлөх чадвартай газруудад арга зүйн дагуу	2,000.0	MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжилт шинжилгээ MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга MNS5061:2001. Нүүрс хүчлийн хий-CO <sub>2</sub> тодорхойлох эзлэхүүний арга MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга MNS0012-1-015:1987. Чимээ шуугиан-Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга MNS0017.2.5.12:8988. Хүхэрлэг хий-SO <sub>2</sub> шинжлэх ТХМ буюу аэрозалины арга MNS0017.2.5.11-1998. Азотын давхар исэл
<b>Усан орчин</b>					
Физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, Хүнд металын шинжилгээ, БХХ болон цэвэршүүлсэн бохир усны стандартад заасан үзүүлэлтүүд	Гүний худгийн ус, шүүрлийн ус	Жилд 2удаа	Усны дээж авах сав, хээрийн хэмжилтийн багаж (pH/EC/TDS meter, TDS-3) зэргийг ашиглан дээж авах ба дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлнэ	800.0	MNS0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах,
<b>Хөрсөн бүрхэвч</b>					

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Хужиртын чулуун нүүрсний орд”-ын  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ явуулах арга хэлбэр, хэрэглэх багаж төхөөрөмж	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Ялзмаг, урвалын орчин (рН), давсжилт, карбонат (CaCO <sub>3</sub> ), хөдөлгөөнт кали (K <sub>2</sub> O), хөдөлгөөнт фосфор (P <sub>2</sub> O <sub>5</sub> ), Шингээгдсэн сууриуд Са, Mg, Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин	Шимт хөрсний овоолго, кемп, нөлөөлөлд өртөөгүй талбай	Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд хоёр удаа	Итгэмжлэгдсэн лабораторийн задлан шинжилгээ	580.0	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам, MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
Хүнд металлууд	Уурхайн кемп, засварын цех, ШТС, нүүрсний агуулах, авто зогсоол			1,000.0	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019.
<b>Амьтны аймаг</b>					
Туруутан амьтдын байршил нутаг, тоо толгой, шилжилт хөдөлгөөн, мөлхөгчдийн нягтшил, зүйлийн бүрдэл, мэрэгчдийн нягтшил зэргийг тогтоох	Төслийн талбайн болон ойр орчмын өндөрлөг цэгүүдэд	Жилд 2 удаа 5 болон 10 сард	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй	500.0	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй
<b>Ургамлын аймаг</b>					
Хяналтын талбай бүрийн (25x25м, 1x1м, 10x10м) ургамлын зүйлийн бүрдэл, бүрхэц, бүлгэмдэлд эзлэх %	Төслийн байгууламжийн талбай дахь судалгааны цэг Төслийн талбайд ойр орших ургамлын бүлгэмдлийн хяналтын цэг	Төсөл хэрэгжилтийн явцад, нөхөн сэргээлтийн шатанд жилд нэг удаа (6-7 сард)	Батлагдсан арга зүйн дагуу	500.0	Батлагдсан арга зүйн дагуу
<b>Орчны хяналт шинжилгээ хийхэд зарцуулагдах урьдчилсан байдлаар тооцсон зардал</b>					<b>5,380.0</b>

### 3.11. Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хэлэлцүүлэх хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч “Илч хужирт” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлэх ба төсөл хэрэгжих аймгийн байгаль орчны газар, сумын Засаг даргын тамгын газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 39. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сэлэнгэ аймгийн байгаль орчны газар	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жилийн эцэст	Цаашид анхаарах зүйлс, Хамтран ажиллах	Сэлэнгэ аймаг
Түшиг сумын Засаг даргын тамгийн газарт	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Хагас жил, жилийн эцэст	Хамтран ажиллах	Түшиг сум
Сэлэнгэ аймгийн Түшиг сумын 1-р багийн Иргэд Нийтийн хуралд	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Хагас жил, жилийн эцэст	Цаашид анхаарах зүйлс, Хамтран ажиллах	багийн ИНХ

### 3.12. “Тэрбум мод” төслийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө

Тарих ургамлыг сонгох Ерөнхийлөгчийн “Тэрбум мод” төслийн хүрээнд орон нутагт	2024	5 га газарт 7,000.0 мянган төгрөгөөр 1 500 ш мод тарьж ургуулах, арчлах ажлыг хийхээр төлөвлөв
---	------	--

мод тарих ажлыг орон нутгийн байгаль орчны газартай хамтарч ажиллах		
---	--	--

### 3.13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

“Илч хужирт” ХХК-ийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлыг доорх хүснэгтэд арга хэмжээ тус бүрээр харуулан нэгтсэн дүнг оруулав. “Илч хужирт” ХХК нь 2024 онд нийт 62,380.0 мян.төг-ний зардлаар уурхайн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 40. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл	Нийт зардал (мян. төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12,300.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10,000.0
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө
4		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
5		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
6		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
7		Тэрбум мод төслийн хүрээнд Тэрбум модны хүрээнд мод тарих
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
<b>Нийт зардал</b>		<b>62 380.0 мян.төг</b>